



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА
Ц.НЯМ-ОСОР ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.23 № 3/338

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем, тэгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

\\10.10.10.20\Bichig_Kherreg\Yawsan_Bichig\2017\0224\SAG10.Docx



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

Санхүүгийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор:
Ц.Наранчимэг
Утас: 261663

Аудитын менежер:
Я.Самбууням
Утас: 260512

Шинжээч:
Б.Баярмаа
Утас: 260512

ТАБ-ын хаяг: ҮАГазар
Чингэлтэй дүүрэг
Цахим хуудас: www.audit.mn

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР 2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга
Хавсралт 2: Аудитын гэрчилгээ
Хавсралт 3: Менежментийн захидал
Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн
тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл	3
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин	3
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа	4
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн	4
5. Материаллаг байдлын түвшин	5
6. Дотоод хяналт	5
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар	5
8. Шилэн дансны мэдээлэл	6
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар	6
10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар	6
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:	6
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:	7
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	7
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	7
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	8
17. Зөвлөмж	8
18. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт	9

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Монгол улсын Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5 дахь заалтыг баримтлан, Монгол улсын Ерөнхий аудиторов 2013 оны 158 дугаар тушаалаар батлагдсан журмын 2.7, Монгол улсын Ерөнхий аудиторов 2016 оны А/98 дугаар тушаалаар батлагдсан эрхийн дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитын код: САГ-2017/1/СТА-ТШЗ

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан Төсөвт байгууллагын “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”, тус байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Байгууллагын удирдлага санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 02 дүгээр сарын 12-ноос 2017 оны 02 дугаар сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн “Монголиан Бизнес Рейтинг Аудит” ХХК-ийн багийн аудиторууд хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2016 оны төсвийн санхүүгийн тайланг 2017 оны 2 дүгээр сарын 12-нд “Монголиан Бизнес Рейтинг Аудит” ХХК-нд ирүүлсэн.

“Монголиан Бизнес Рейтинг Аудит” ХХК аудитыг 2017 оны 2 дугаар сарын 12-ноос 2017 оны 2 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 2 дугаар сарын 26-нд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын дарга нь Монгол улсын “Төсвийн тухай”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

МУ-ын Засгийн газрын 2016 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн дугаар 4 тогтоолоор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар шинээр байгуулагдаж, татан буугдсан “Худалдан авах ажиллагааны газар”-ын хаалтын санхүүгийн тайлангийн эцсийн

үлдэгдлийг эхний үлдэгдэл болгосон байна. Уг тогтоолоор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар 75 хүний орон тоотойгоор батлагдсан.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үйл ажиллагааны стратеги бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг Засгийн газрын тухай хууль, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч батлах тухай Улсын Их Хурлын 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн 12-р тогтоол, “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зохион байгуулалтын бүтцийг батлах тухай “ Ерөнхий сайдын 2016 оны 8-р сарын 12-ны өдрийн 37 дугаар захирамжыг тус тус үндэслэн боловсруулсан байна

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн зорилго нь: Төрийн өмчийн эд хөрөнгийг эзэмших, ашиглах, хамгаалах болон төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшил, хадгалалт, хамгаалалтыг хариуцах, бүртгэлээр хяналт тавих, төрийн өмчит хуулийн этгээдэд компанийн сайн засаглалыг нэвтрүүлэх, төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх, стратеги төлөвлөгөөг батлах, төрийн өмчийг хувьчлах, хуулийн этгээдийг шинээр байгуулах, өөрчлөх, татан буулгах, төрийн өмчийн улсын үзлэг, тооллого хийх, орон нутгийн өмчийн асуудлаар мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд худалдан авах ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, сургалт зохион байгуулахад оршино.

Үйл ажиллагааны стратеги зорилт нь:

- Төрийн өмчийн талаарх хууль тогтоомж, бодлого, чиглэл, баримт бичгийн төсөл боловсруулах, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн засаглалыг сайжруулах;
- Төрийн өмчийн эзэмших, ашиглах, хамгаалахтай холбоотой бүртгэл, тооллого явуулах, төрийн өмчийн бүрэн бүтэн байдал, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн байдалд хяналт тавих;
- Худалдан авах ажиллагааг төлөвлөн батлагдсан төсвийн хүрээнд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай байх зарчимд тулгуурлан зохион байгуулах, тайлагнах;
- Захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, хууль, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, мэдээлэл, технологийн хөгжлийг хангах.

Тус байгууллагын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын горим, хяналтын болон нарийвчилсан сорил, түүний үр дүн:

Аудитыг гүйцэтгэхдээ Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”, Шилэн дансны тухай хууль, бусад холбогдох заавар журмуудыг шалгуур болгон, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2014 оны 203 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн тайлангийн аудитын журам”, гарын авлагын дагуу гүйцэтгэв.

Аудитаар Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс гүйцэтгэх удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 24-ыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь санхүүгийн тайлан бэлтгэх, толилуулахад тууштай мөрдөгдөх тухайн байгууллагын баталсан зүй тогтол болон тогтсон дэг журмын суурь юм. Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ өгч, аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар нь санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг Санхүүгийн тооцоолох ХХК-ний “Acolous 3.0” санхүүгийн програмаар боловсруулан, санхүүгийн тайлан бэлтгэх заавар журмын дагуу гаргаж бэлтгэсэн байна.

Материаллаг байдлын түвшин:

2016.12.31-нээр дуусгавар болсон санхүүгийн тайланд тусгагдсан тоон үзүүлэлтүүдээр материаллагийн түвшинд нөлөөлөх хүчин зүйлсийн нөлөөллийг урьдчилан үнэлж, нийт орлогын батлагдсан төсөв болох 509,035.2 мянган төгрөгийг материаллаг байдлын суурь болгон түүний 1%-иар тооцож, материаллаг байдлын түвшинг 5.1 сая төгрөгөөр урьдчилан тогтоов. Гүйцэтгэлээр материаллаг байдлыг дахин хянаж, өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлж байна. Төрийн сан төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлыг хөтөлбөр, зориулалт, ангилалын дагуу хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт 2016 онд нийт 470,761.1 мянган төгрөгийн төсөв батлагдсан. Үүнээс цалин 335,408.9 мянган төгрөг, НДШ 36,989.7 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 33,932.9 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварт 1,818.4 мянган төгрөг, томилолт зочны зардалд 5,112.7 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ 51,508.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 1,312.5 мянган төгрөг, тэтгэмж урамшуулал 4,773.0 мянган төгрөгийг хувиарлан төсөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 501,791.5 мянган төгрөгийн залцуулалт гарч, 31,030.4 мянган төгрөгийн хэтрэлттэй байна. Энэ нь Худалдан авах ажиллагааны газрын

ашиглалтын зардлын төлөөгүй байсан 30,973.6 мянган төгрөгийн төлбөр нэмэлт санхүүжилтээр авч, төлсөнтэй холбоотой байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар шинээр байгуулагдаж, татан буугдсан “Худалдан авах ажиллагааны газар”-ын хаалтын санхүүгийн тайлангийн эцсийн үлдэгдлийг эхний үлдэгдэл болгосон байна.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 8.3. “Төрийн аудитын байгууллага нь өөрийн санаачилгаар шилэн дансны мэдээлэлд аудит хийж болно” гэсэн заалтын дагуу тус байгууллагын вебсайт хуудасанд шилэн дансны мэдээллийг шалгахад дараах байдалтай байна. Үүнд:

1. Төсөв гүйцэтгэлийн талаар
 - Дараа жилийн төсвийн төслийг бүтэн жилээр байршуулсан.
 - Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт сар, улирал, хагас, бүтэн жилээр байршуулсан.
 - Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтийг сар бүр батлагдсан төсөв, гүйцэтгэлээр байршуулсан.
 - Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан хагас, бүтэн жилээр байршуулаагүй.
 - Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан хагас, бүтэн жилээр байршуулаагүй.
 - Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий мэдээлэлд санхүүжилтийн орлогыг сар бүр байршуулсан.
 - Хагас жилийн санхүүгийн тайлан байршуулаагүй.
 - Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт байршуулаагүй.
 - Байгууллагын батлагдсан төсвийг байршуулаагүй.
2. Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт
 - Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэлийг сар бүр байршуулсан.
 - Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл байршуулсан.
 - Худалдан авах ажиллагааны тайланг батлагдсан төсөв, гэрээ, гүйцэтгэл, тайлбарыг бүтэн жилээр байршуулсан.
3. Бусад мэдээлэл
 - Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэлийг сар бүр байршуулсан.
 - Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг сар бүр байршуулсан.
 - Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлтийг сар бүр байршуулсан.
 - Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийг сар бүр байршуулсан.
 - Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн сар бүр байршуулсан.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 24 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 24 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

МУ-ын Засгийн газрын 2016 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн дугаар 4 тогтоолоор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар шинээр байгуулагдаж, татан буугдсан “Худалдан авах ажиллагааны газар”-ын хаалтын санхүүгийн байдлын тайлангийн эцсийн үлдэгдлийг санхүүгийн байдлын тайлангийн эхний үлдэгдэл болгосон байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын санхүүгийн тайлангийн эхний үлдэгдэлд “Худалдан авах ажиллагааны газар”-тай холбоотой үүссэн 349,116.3 мянган төгрөгийн өглөг, 1,272,912.0 мянган төгрөгийн авлага бүртгэгдсэн байна. Үүнд:

- ХХОАТ-ын өглөг 5,118.6 мянган төгрөг.
- Байгууллагад төлөх өглөг 3,997.7 мянган төгрөг.
- Үнэт цаасны өглөг 340,000.0 мянган төгрөг.
- Урьдчилж гарсан зардал 1,272,912.0 мянган төгрөг.

Тус байгууллага тайлант хугацаанд нийт 349,116.3 мянган төгрөгийн өр төлбөрийг төлж барагдуулсан байна.

Тайлант хугацаанд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоолоор нийт 21,814,052.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг балансаас балансад шилшүүлэн авч бүртгэж тайлагнасан байна. Үүнд:

- 2016 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 104 дүгээр тогтоолоор Худалдан авах ажиллагааны газраас 342,425.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө.
- 2016 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 105 дугаар тогтоолоор Сангийн яамнаас 20,474,644.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө.
- 2016 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 112 дугаар тогтоолоор Хөдөлмөрийн яамнаас 556,988.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө.
- 2016 оны 10 дугаар сарын 27-ны 125 тогтоолоор Аж үйлдвэрийн яамнаас 74,089.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө.
- 2016 оны 10 дугаар сарын тогтоолоор Мэдээлэл технологийн газраас 67,500.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө.
- 2016 оны 9 дугаар сарын тогтоолоор Ашигт малтмалын газраас 298,404.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, орлого санхүүжилт, үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалт, цалин, НДШ, зардал, НДШ, ХХОАТ-ын ногдуулалт, төлөлт үлдэгдлийн тооцооллуудыг түүвэрчлэн, нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа./ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 100 хувь, мөнгөн хөрөнгийн 100 хувь, авлага, өр төлбөрийн 80 хувь, цалин, НДШ, 100 хувь, нийт хөрөнгийн 75 хувийг тус тус эзэлж байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитаар дараах алдаа, зөрчил илэрсэн байна. Үүнд:

Завсарын аудитаар

1. Мөнгөн гүйлгээний тайланд нэмэлт санхүүжилтийн 30,973.6 мянган төгрөгийн орлогыг бүртгэж тайлагнаагүй.

2. Мөнгөн гүйлгээний тайланд ХЧТАТ-ын 3,529.3 мянган төгрөгийг ндш-ийн зардлаар бүртгэж тайлагнаагүй. буюу ажил олгогчын нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаар бүртгэж тайлагнасан
3. Санхүүгийн үр дүнгийн тайланд жирэмсэн болон амаржсан, ХЧТАТ-ын 1,496,6 мянган төгрөгийн орлогыг бүртгэж, ХЧТАТ-ын 3,529.3 мянган төгрөгийг ажил олгогчын нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаар тайлагнасан. Эдгээр нь УСНББОУС 1, 2, 12,15 Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Гарсан алдаа, зөрчлийг аудитын явцад залруулсан.

Жилийн эцсийн аудитаар

4. Санхүүгийн үр дүнгийн болон Мөнгөн гүйлгээний тайланд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Худалдан авах ажиллагааны газар Интерактив ХХК-ны хооронд байгуулсан 2014 оны ХААГ/2014/143 гэрээний дагуу тус байгууллагын хөрөнгө оруулалтын /900008309/ тоот харилцах дансанд орсон, цахим 2 системийн санхүүжилтийн 340,000.00 мянган төгрөгийн орлогыг бүртгэж тайлагнаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.5-д “бүх орлого” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Гарсан зөрчлийг аудитын явцад залруулсан.

5. Дээрх 340,000.00 мянган төгрөгийг Санхүүгийн үр дүнгийн тайланд зардлаар бүртгэж тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дүгээр зүйлийн 20.1.4-д “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Гарсан зөрчлийг аудитын явцад залруулсан.

6. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Худалдан авах ажиллагааны газар Интерактив ХХК-ны хооронд байгуулсан Цахим-2 мэдээлэлийн системийн 2014 оны ХААГ/2014/143 гэрээний биелэлтийг хянаж, хөрөнгийг бүртгэж тайлагнах, асуудлыг шийдвэрлэх ажиллагаа хийгдээгүй байна.

Шийдвэрлэсэн: 2014 оны ХААГ/2014/143 гэрээний биелэлтийг хянаж, хөрөнгийг актаар хүлээн авч, бүртгэж тайлагнах асуудлыг шийдвэрлэх талаар зөвлөмж хүргүүлсэн.

7. Санхүүгийн тайлангийн тодруулгыг бэлтгээгүй байна. Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын хавсралт 3-ыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын хавсралт 3-ыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж хүргүүлсэн

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Залруулагдаагүй алдаа байхгүй.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Худалдан авах ажиллагааны газар Интерактив ХХК-ны хооронд байгуулсан цахим худалдан авах ажиллагааны 2014 оны ХААГ/2014/143 гэрээний дагуу 2016 оны 12-р сарын 31-ны байдлаар 1,272,912.0 мянган төгрөгийн урьдчилж гарсан зардлын авлагатай байна. Гэтэл тус гэрээний биелэлтийг хянаж, хөрөнгийг хүлээн авч, бүртгэж тайлагнах үйл ажиллагаа хийгдээгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Тус байгууллагын төсвийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 719,528.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч, 719,528.8 мянган төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд залруулж ажилласан.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Тус байгууллага 2016 онд шинээр байгуулагдсан учир 2015 онд аудит хийгдээгүй.

Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

Санхүүгийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор:
Ц.Наранчимэг
Утас: 261663

Аудитын менежер:
Я.Самбууням
Утас: 260512

Шинжээч:
Б.Баярмаа
Утас: 260512

ТАБ-ын хаяг: ҮАГазар
Чингэлтэй дүүрэг
Цахим хуудас: www.audit.mn

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР 2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол № 1

Асуудал 1 Санхүүгийн тайлагнал

Асуудал 2 Үндсэн хөрөнгө

Тэргүүлэх ач холбогдол №2 :

Асуудал 1 Нягтлан бодох бүртгэлийн
бодлогын баримт бичиг

Менежментийн захидал

Манай Аудитын компани Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 дахь заалт, “Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайланд аудит хийх чиг үүргээ аудитын бусад байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгэх журам”-ын 2.7, Монгол улсын Ерөнхий аудиторовн 2016 оны А/98 дугаар тушаалаар батлагдсан эрхийн дагуу “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар”-ын 2016 оны санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бид аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг танай байгууллагын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү Менежментийн захидлын агуулга нь Аудитын олон улсын стандартад тулгуурлан бидний гүйцэтгэсэн аудитын горим, ажлын үр дүнгээс үүдэн гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Аудитын байгууллагын энэхүү зөвлөмж та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад шаардлагатай баримт материалыг цаг хугацаандаа гаргаж өгч, биднийг мэдээллээр хангаж байсныг сайшаан тэмдэглэж байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан танай байгууллагын удирдлага болон ажилтнуудад талархал илэрхийлье.

ҮАГ-ын ажиглалт

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг 1. Худалдан авах ажиллагааны газар Интерактив ХХК-ны хооронд байгуулсан Цахим-2 мэдээлэлийн системийн 2014 оны ХААГ/2014/143 гэрээний биелэлтийг хянаж, хөрөнгийг бүртгэж тайлагнах, асуудлыг шийдвэрлэх ажиллагаа хийгдээгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

2014 оны ХААГ/2014/143 гэрээний биелэлтийг хянаж, хөрөнгийг актаар хүлээн авч, бүртгэж тайлагнах асуудлыг шийдвэрлэх.

Эрсдэлүүд:

1. Гэрээний үүргийн хэрэгжилт хангагдахгүй байх,
2. Холбогдох шийдвэр зөрчигдөх
3. Хөрөнгө шамшигдах зэрэг эрсдлүүдийг агуулж байна

Үйлчлүүлэгчийн хариу

ҮАГ-ын ажиглалт

Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын хавсралт 3-ыг зөрчсөн байна.

ҮАГ-ын зөвлөмж

1. Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын хавсралт 3-ыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж хүргүүлсэн.

Эрсдэлүүд:

1. Хууль журам хэрэгжихгүй байх
2. Санхүүгийн тайлан иж бүрэн бэлтгэгдэхгүй байх
3. Удирдлага иж бүрэн, үнэн зөв мэдээллээр хангагдахгүй байх

Үйлчлүүлэгчийн хариу

ТӨРИЙН ӨМЧ БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР
АУДИТ ХИЙГДСЭН 2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
2016 оны 12-р сарын 31-нээр дуусгавар болсон тайлант жил

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	3	-	-
2	Кассанд байгаа бэлэн мөнгө		-	-
3	жижиг мөнгөн сан		-	-
4	Банкинд байгаа бэлэн мөнгө /төгрөгөөр/		-	-
5	/гадаад валютаар/		-	-
6	Богино хугацаат хадгаламж		-	-
7	Замд яваа мөнгөн хөрөнгө		-	-
8	АВЛАГА	4	-	-
9	Төлбөртэй үйлчилгээний авлага		-	-
10	Байгууллагаас авах авлага		-	-
11	УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ТӨЛБӨР		-	1,272,912,000.00
12	Урьдчилгаа тооцоо		-	-
13	Урьдчилж гарсан зардал		-	1,272,912,000.00
14	БАРАА МАТЕРИАЛ	5	-	9,105,980.00
17	Түлш шатах тослол материал		-	9,105,980.00
23	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		-	1,282,017,980.00
24	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ			
25	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6	-	20,416,688,324.90
26	Биет хөрөнгө		-	20,416,512,324.90
27	Барилга байгууламж		-	20,367,994,383.00
28	Хуримтлагдсан элэгдэл		-	(504,775,239.20)
29	Авто тээврийн хэрэгсэл		-	529,294,143.40
30	Хуримтлагдсан элэгдэл		-	(281,201,324.69)
31	Машин, тоног төхөөрөмж		-	487,441,287.72
32	Хуримтлагдсан элэгдэл		-	(401,982,127.17)
33	Тавилга, эд хогшил		-	396,808,582.14
34	Хуримтлагдсан элэгдэл		-	(177,067,380.30)
44	Биет бус хөрөнгө		-	176,000.00
45	Программ хангамж		-	-
46	Хуримтлагдсан элэгдэл		-	-
47	Бусад		-	32,514,501.60
48	Хуримтлагдсан элэгдэл		-	(32,338,501.60)
50	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		-	20,416,688,324.90
51	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		-	21,698,706,304.90
66	НИЙТ ӨР, ТӨЛБӨРИЙН ДҮН		-	-
67	Засгийн газрын хувь оролцоо		-	-
68	Хуримтлагдсан үр дүн		-	21,698,706,304.90
69	Өмнөх үеийн үр дүн		-	-
70	Тайлант үеийн үр дүн		-	21,698,706,304.90
72	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН		-	21,698,706,304.90
73	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН		-	21,698,706,304.90

**ТӨРИЙН ӨМЧ БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР
АУДИТ ХИЙГДСЭН 2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН
2016 оны 12-р сарын 31-нээр дуусгавар болсон тайлант жил**

/төгрөгөөр/

Дансны код	ҮЗҮҮЛЭЛТ	тодруулга	Өмнөх он	Тайлант он
	<u>1</u>	<u>2</u>	<u>3</u>	<u>4</u>
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	1	0.00	26,712,810,174.87
	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		-	849,035,200.00
	Улсын төсвөөс		-	447,088,100.00
	Урсгал		-	447,088,100.00
	Хөрөнгийн		-	340,000,000.00
	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /тусгай/		-	-
	Орон нутгийн төсвөөс		-	-
	Төсөвт байгууллагын үндсэн үйл		-	-
	Нийгмийн даатгалын сангаас		-	-
	Бусад тусгай зориулалтын сангаас		-	-
	Тусламжийн орлого		-	61,947,100.00
	Бараа үйлчилгээний орлого		-	25,863,774,974.87
	Өмчийн орлого		-	40,000.00
	Төсөвт байгууллагын ажил үйлчилгээний орлого		-	-
	Торгууль төлбөрийн орлого		-	-
	Үнэ төлбөргүй орлого		-	21,789,957,511.97
	Хөрөнгийн		-	4,073,777,462.90
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ҮР ДҮН (1)		-	26,712,810,174.87
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	2	-	5,014,103,869.97
	АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБООТОЙ ЗАРДАЛ		-	367,139,741.47
	Цалин, хөлс ба нэмэгдэл урамшил		-	327,122,373.02
	Цалин		-	310,360,272.08
	Цалингийн тусгай нэмэгдлүүд		-	16,762,100.94
	Үр дүнгийн урамшуулал		-	-
	Гэрээт ажлын цалин		-	-
	Нийгмийн хамгааллын шимтгэл		-	40,017,368.45
	Тэтгэвэр тэтгэмжийн шимтгэл		-	26,743,130.38
	Тэтгэмжийн шимтгэлийн даатгал		-	2,633,246.23
	ҮОМШ өвчний даатгал		-	3,325,309.95
	Ажилгүйдлийн даатгал		-	665,062.99
	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл		-	6,650,618.90
	Бараа үйлчилгээний урсгал зардал		-	4,646,964,128.50
	Бусад бараа үйлчилгээний зардал		-	4,646,964,128.50
	Бичиг хэргийн материал		-	24,873,766.00
	Тээвэр, шатахууны зардал		-	10,660,000.00
	Шуудан холбооны зардал		-	5,449,704.00
	Дотоод томилолтын зардал		-	2,724,873.00
	Бараа матриал акталсны зардал		-	-
	Ном хэвлэлийн зардал		-	-
	Хичээл сургалт үйлдвэрлэлийн зардал		-	950,000.00
	Эрдэм шинжилгээний ажлын зардал		-	-
	Жижиг эд хогшил худалдан авах		-	-
	Бага үнэтэй түргэн элэгдэх		-	13,609,619.00
	Төлбөр хураамж, жижиг татварууд		-	-

Харуул хамгаалалтын зардал		-	-
Тээврийн хэрэгсэлийн даатгал		-	-
Тээврийн хэрэгсэлийн татвар		-	-
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр		-	-
Маягт хэвлүүлэх зардал		-	-
Урсгал засварын зардал		-	7,423,200.00
Бараа үйлчилгээний бусад зардал		-	-
Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний		-	87,101,364.00
Хөрнгийн зардал		-	340,000,000.00
Төвлөрүүлэх шилжүүлэх зардал		-	4,081,061,175.82
Холбоо суваг ашигласан зардал		-	-
Элэгдлийн зардал		-	72,910,426.68
шагнал урамшуулал		-	200,000.00
Хог хаягдал		-	-
НИЙГМИЙН ХАМГААЛАЛЫН ЗАРДАЛ		-	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН		-	5,014,103,869.97
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН		-	21,698,706,304.90
Гадаад валютын ханшийн зөрүүгийн гарз /бодит/		-	-
үндсэн хөрөнгө худалсаны гарз		-	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРЛАГЫН ДҮН (5)		-	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН		-	21,698,706,304.90

ТӨРИЙН ӨМЧ БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР
АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГИЙН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
2016 оны 12р сарын 31-нээр дуусгавар болсон тайлант жил

төгрөгөөр

	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
	2014 оны 12-р сарын 31-ээрх	7,511,605.81	-	1,164,912,265.09	1,172,423,870.90
	Нягтлан бодох бүртгэлийн	-	-	-	-
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,511,605.81	-	1,164,912,265.09	1,172,423,870.90
	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний				-
	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний		-		-
	Орлогын тайланд хүлээн				-
	Тайлант үеийн үр дүн				-
	2015 оны 12-р сарын 31-ээрх				
	Нягтлан бодох бүртгэлийн				-
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-		21,698,706,304.90	21,698,706,304.90
	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний				-
	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний				-
	Орлогын тайланд хүлээн				-
	Тайлант үеийн үр дүн		-	21,698,706,304.90	21,698,706,304.90
					-
	2016 оны 12-р сарын 31-аарх үлдэгдэл	-	-	21,698,706,304.90	21,698,706,304.90

**ТӨРИЙН ӨМЧ БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР
АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
2016 оны 12-р сарын 31-нээр дуусгавар болсон тайлант жил**

/төгрөгөөр/

Дансны код	ҮЗҮҮЛЭЛТ	тодруулга	Өмнөх он	Тайлант он
	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		-	4,922,852,662.90
	Улсын төсвөөс		-	849,035,200.00
	Урсгал		-	447,088,100.00
	Хөрөнгийн		-	340,000,000.00
	Нэмэлт санхүүжилт			61,947,100.00
	Орон нутгийн төсвөөс		-	-
	Урсгал		-	-
	Хөрөнгийн		-	-
	Бусад төсөвт байгууллагаас		-	-
	Нийгмийн даатгалын сангаас		-	-
	Төсвийн урамшуулал		-	-
	Тусламжийн орлого		-	-
	Бараа үйлчилгээний орлого		-	4,073,817,462.90
	Өмчийн орлого		-	253,802,250.00
	Төсөвт байгууллагын ажил үйлчилгээний орлого		-	40,000.00
	Торгууль, төлбөрийн орлого		-	3,275,076,270.29
	Бусад орлого		-	544,898,942.61
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1.00	-	4,922,852,662.90
	АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБООТОЙ ЗАРДАЛ		-	372,258,358.08
	Цалин, хөлс ба нэмэгдэл урамшил		-	335,363,658.08
	Цалин		-	313,954,958.08
	Цалингийн тусгай нэмэгдлүүд		-	21,408,700.00
	Үр дүнгийн урамшуулал		-	-
	Гэрээт ажлын цалин		-	-
	Нийгмийн хамгааллын шимтгэл		-	36,894,700.00
	Тэтгэвэрийн даатгал		-	36,894,700.00
	Тэтгэмжийн даатгал		-	-
	ҮОМШ өвчний даатгал		-	-
	Ажилгүйдлийн даатгал		-	-
	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл		-	-
	Бараа үйлчилгээний урсгал зардал		-	4,210,594,304.82
	Тогтмол зардал		-	-
	Гэрэл цахилгааны зардал		-	-
	Түлш, халаалтын зардал		-	-
	Цэвэр, бохир усны зардал		-	-
	Үйл ажиллагааны зардал		-	-
	Хоол		-	-
	Эм		-	-
	Зөөлөн эдлэл, нормын хувцас		-	-
	Бусад бараа үйлчилгээн зардал		-	4,210,594,304.82
	Бичиг хэргийн материал		-	12,769,900.00
	Гээвэр, шатахууны зардал		-	7,277,674.00
	Шуудан холбооны зардал		-	5,449,704.00
	Дотоод томилолтын зардал		-	2,724,873.00
	Гадаар томилолт		-	-

Ном хэвлэлийн зардал		-	-
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн зардал		-	1,150,000.00
Бага үнэтэй түргэн элэгдэх		-	5,636,413.00
Жижиг эд хогшил худалдан авах		-	-
Тээврийн хэрэгсэлийн даатгал		-	-
Тээврийн хэрэгсэлийн татвар		-	-
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр		-	-
Маягт хэвлүүлэх зардал		-	-
Урсгал засварын зардал		-	7,434,200.00
Хөрөнгийн зардал		-	-
Үдийн цай		-	-
Төвлөрүүлэх шилжүүлэг		-	4,081,061,175.82
Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний хөлс		-	87,090,365.00
НИЙГМИЙН ХАМГААЛАЛЫН ЗАРДАЛ		-	-
Нэг удаагийн буцалтгүй тусламж		-	-
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал		-	-
Хуульд заасан үндэслэлээр ТАХ-д өгсөн тэтгэлэг		-	-
Хөдөө ОН-д тогтвор сууршилтай ажилласаны тэтгэлэг		-	-
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж		-	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)		-	4,582,852,662.90
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I-II)		-	340,000,000.00
Хөрөнгийн орлого			
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого			
Бусад хөрөнгө борлуулсны орлого			
Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын Дүн IV)		-	-
Биет ба биет бус хөрөнгө худалдаж авсан зардал			340,000,000.00
Хөрөнгийн бусад зардал			
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (V)		-	340,000,000.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ VI=(IV-V)		-	(340,000,000.00)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ VII		-	-
Авсан зээл			
Төлсөн зээл			
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ ДҮН (VIII)		-	-
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН (IX)=(VII)+(VIII)		-	(0.00)
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			-
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			-

ТӨРИЙН ӨМЧ БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР
АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН
2016 оны 12р сарын 31-нээр дуусгавар болсон тайлант жил

/ төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	810,761,100.00	841,791,487.08	(31,030,387.08)	103.83
А. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	470,761,100.00	501,791,487.08	(31,030,387.08)	106.59
1. Бараа, үйлчилгээний зардал	470,761,100.00	501,791,487.08	(31,030,387.08)	106.59
1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	335,408,700.00	335,363,658.08	45,041.92	99.99
Үндсэн цалин	314,000,200.00	313,954,958.08	45,241.92	99.99
Нэмэгдэл, урамшил	21,408,500.00	21,408,700.00	(200.00)	100.00
Гэрээт ажлын цалин			-	
Үр дүнгийн урамшуулал			-	
1.2 Нийгмийн даатгалын шимтгэл	36,894,900.00	36,894,700.00	200.00	100.00
Тэтгэврийн даатгал	23,478,500.00	36,894,700.00	(13,416,200.00)	157.14
Тэтгэмжийн даатгал	2,683,600.00		2,683,600.00	-
ҮОМШ өвчний даатгал	3,353,900.00		3,353,900.00	-
Ажилгүйдлийн даатгал	670,500.00		670,500.00	-
Байгууллагад төлөх ЭМД-хураамж	6,708,400.00		6,708,400.00	-
Бараа үйлчилгээний урсгал зардалд	98,457,500.00	129,533,129.00	(31,075,629.00)	131.56
1.3 Байр ашиглалттай холбоотой	-	-	-	
Гэрэл цахилгаан			-	
Түлш, халаалт			-	
Цэвэр, бохир ус			-	
Байрны түрээс			-	
Норматив зардал	-	-	-	
Хоол			-	
Хүнс			-	
Норм хувцас худалдан авах			-	
Хангамж бараа материал	33,932,900.00	31,133,691.00	2,799,209.00	91.75
Бичиг хэргийн зардал	9,898,000.00	12,769,900.00	(2,871,900.00)	129.01
Тээвэр (шатахуун)	7,287,000.00	7,277,674.00	9,326.00	99.87
Шуудан, холбоо	10,202,500.00	5,449,704.00	4,752,796.00	53.42
Хог хягдал			-	
Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	6,545,400.00	5,636,413.00	908,987.00	86.11
Ном хэвлэл			-	
Эд хогшил урсгалын зардал	1,818,400.00	7,434,200.00	(5,615,800.00)	408.83
Урсгал засварын зардал	1,818,400.00	7,434,200.00	(5,615,800.00)	408.83
Бусдаар гүйцэтгүүлсэн зардал	51,508,000.00	87,090,365.00	(35,582,365.00)	169.08
Хүүхэд хөгжил хөтөлбөр			-	
Холбоо суваг ашигласны зардал			-	
Дотоод албан томилолт	5,112,700.00	2,724,873.00	2,387,827.00	53.30
Бусад зардал	1,312,500.00	1,150,000.00	162,500.00	87.62
бусад зардал			-	
Хичээл сургалт	1,312,500.00	1,150,000.00	162,500.00	87.62
Урсгал шилжүүлэг	4,773,000.00	-	4,773,000.00	-
Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	4,773,000.00		4,773,000.00	-
НЭГ удаагийн тэтгэмж урамшуулал			-	
Төвлөрүүлэх шилжүүлэг			-	
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	340,000,000.00	340,000,000.00	-	
Тоног төхөөрөмж	340,000,000.00	340,000,000.00	-	
Улсын нөөцийн эх үүсвэр нэмэгдүүлэх			-	
Эргэж төлөгдөх төлбрийг хассан цэвэр			-	

ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	470,761,100.00	509,035,200.00	(38,274,100.00)	108.13
Төсвөөс санхүүжүүлэх	458,261,100.00	509,035,200.00	(50,774,100.00)	111.08
Үндсэн үйл ажиллагааны орлогоос	12,500,000.00		12,500,000.00	
Үндсэн бус үйл ажиллагааны орлогоос		40,000.00	(40,000.00)	
III. БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.00
Төсвийн байгууллага	1	1	-	100.00
Ажиллагсад	64	64	-	100.00
Суралцагчид (хүүхдийн тоо)			-	